

## **АРЬСНЫ ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН 2023 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТЭНД ХИЙСЭН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ**

2023 оны байгууллагын гүйцэтгэлийн жилийн төлөвлөгөөнд 7 зорилго 11 зорилтын хүрээнд нийт 42 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Үүнд:

1. Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тасралтгүй байдлыг хангах, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгын хүрээнд төлөвлөсөн 16 ажлын хэрэгжилт 98.1 хувь байна. Эрүүл мэндийн сайдаас тусгайлан үүрэг болгосон арга хэмжээний зорилтын хэрэгжилт 96 хувь, арьс харшлын өвчний тусламж, үйлчилгээг чанартай үзүүлэх, нэр төрөл, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилтын хэрэгжилт 99 хувь байна.
2. Иргэдэд нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг хүргэх зорилгын хүрээнд төлөвлөсөн 2 ажлын хэрэгжилт 100 хувь байна. Арьс харшлын өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрсдэлт хүчин зүйлсийг бууруулах чиглэлээр олон нийтэд эрүүл мэндийн боловсрол олгох, мөн үйлчлүүлэгчдэд арьс, харшлын чиглэлээр эрүүл мэндийн боловсрол олгох мэдээлэл, сургалт, сурталчилгааны ажил бүрэн хэрэгжсэн байна.
3. Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг хангаж эрсдэлээс сэргийлэх зорилгын хүрээнд төлөвлөсөн нийт 11 ажлын хэрэгжилт 95.4 хувь байна. Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанарын удирдлагын тогтолцоо, арга хэрэгслийг сайжруулан, тасралтгүй байдлыг хангах зорилтын хэрэгжилт 100 хувь, эмнэлгийн халдвар, хамгаалал, аюулгүй байдлыг хангах зорилтын хэрэгжилт 75 хувь байна.
4. Тасралтгүй суралцагч байгууллага байж, хүний нөөцийг хөгжүүлэх зорилгын хүрээнд төлөвлөсөн 8 ажлын хэрэгжилт 97.5 хувь байна. Тухайлбал, арьс харшил, эмчилгээний гоо заслын чиглэлээр чадварлаг мэргэшсэн хүний нөөцөөр хангах зорилтын хэрэгжилт 100 хувь, эмч, эмнэлгийн ажилчдын нийгмийн баталгааг сайжруулж, дэмжлэгт удирдлагаар хангаж ажиллах зорилтын хэрэгжилт 90 хувь, эмч, эмнэлгийн ажилчдын ёс зүй, сахилга хариуцлагыг сайжруулах зорилтын хэрэгжилт 100 хувь байна.
5. Дэвшилтэт шинэ техник, технологийг нэвтрүүлэх зорилтын хүрээнд эмнэлгийн тусламж, үйлчилгээнд шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах төлөвлөгөөний хэрэгжилт 90 хувь байна.

6. Үйлчлүүлэгчдэд ээлтэй, аюулгүй орчныг бүрдүүлэх зорилтын хүрээнд төлөвлөсөн 2 ажлын хэрэгжилт 100 хувь байна.
7. Хагас бие даасан засаглалыг хөгжүүлэх, санхүүгийн ил тод байдлыг хангаж ажиллах зорилтын хүрээнд төлөвлөсөн 3 ажлын хэрэгжилт 96.6 хувь байна.

### **ДҮГНЭЛТ**

2023 оны байгууллагын гүйцэтгэлийн жилийн төлөвлөгөөнд 7 зорилго 11 зорилтын хүрээнд төлөвлөсөн 42 арга хэмжээний хэрэгжилт 96.8 хувь байна.Цаашид эмнэлгийн халдвар, хамгаалал, аюулгүй байдлыг хангах зорилгын хүрээнд төлөвлөсөн ажлуудыг бүрэн хэрэгжүүлж, дэвшилтэт шинэ техник, технологийг нэвтрүүлэх ажлыг анхаарах шаардлагатай байна.

ДХН-ИЙН ДАРГА

Т.БАЯРМАА